

## АЖЛЫН ДААЛГАВАР

Төслийн нэр	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын нэгдсэн төсөл
Байршил	Монгол Улс, Улаанбаатар
Ажлын даалгаврын нэр	Тэтгэврийн шинэчлэлийн зөвлөх
Үйлчилгээний нэр	Тэтгэврийн тогтолцооны шинэчлэлийн цогц бодлогын стратегийн хувилбарууд, болон оролцогч талуудын оролцогч талуудын хэрэгцээ, хандлага, ойлголт, мэдээллийн шаардлагын шинжилгээг хийх
Гэрээний төрөл	Зөвлөх үйлчилгээ
Хэлний мэдлэг:	Монгол, Англи хэл
Гэрээний хугацаа:	2026.06.10-2026.11.16 (5 сар )

### ҮНДЭСЛЭЛ

Дэлхий дахинд хүн амын насжилт нэмэгдэх, хөдөлмөрийн зах зээлийн бүтэц өөрчлөгдөх зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр тэтгэврийн тогтолцоог илүү тогтвортой, уян хатан, олон тулгуурт хэлбэрт шилжүүлэх шаардлага улам бүр нэмэгдэж байна. Монгол Улсын хувьд ч дээрх чиг хандлагын нөлөөгөөр тэтгэврийн даатгалын тогтолцооны болон параметрийн шинэчлэлийг үе шаттайгаар, даатгуулагч, ажил олгогч, тэтгэвэр авагч болон улсын төсөвт үзүүлэх ачааллыг зохистой түвшинд хадгалах зарчмаар хэрэгжүүлж ирсэн.

Гэсэн хэдий ч цаашид тэтгэврийн даатгалын тогтолцоог даатгуулагчийг урт хугацаанд шимтгэл төлөхийг урамшуулах, тэтгэврийн доод хэмжээг үе шаттайгаар шинэчлэх, ахмад настанд амьжиргааны наад захын хэрэгцээг хангахуйц түвшний тэтгэвэр олгох нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр тогтолцооны болон параметрийн нэмэлт шинэчлэл хийх шаардлага хэвээр байна.

Тухайлбал, Монгол Улсад нийгмийн даатгалын болон цэргийн тэтгэвэр авагчдын тоо 2024 онд 531.8 мянга байгаа бол Дэлхийн банкны тооцооллоор 2030 онд 605.0 мянга, 2040 онд 728.0 мянга, 2050 онд 1.1 саяд хүрэх төлөвтэй байна. Үүний зэрэгцээ 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн харьцаа 2020 онд 4 байсан бол 2024 онд 5 болж өссөн бөгөөд 2030 онд 7 болох тооцоолол байна. Энэхүү хандлага нь тэтгэврийн даатгалын сангийн санхүүгийн тогтвортой байдалд томоохон дарамт учруулах эрсдэл юм.

Монгол Улсын тэтгэврийн даатгалын тогтолцоо нь хуваарилалтын зарчимд суурилсан бөгөөд тэтгэврийн хэмжээг цалин болон хийсвэр нэрийн дансны аргад тулгуурлан тогтоож байгаа нь хүн амзүйн болон эдийн засгийн өөрчлөлтөд өндөр мэдрэг байна. Иймээс урт хугацаанд тогтвортой байдлыг хангах зорилгоор тэтгэврийн тогтолцооны бүтэц, параметр, засаглалыг цогцоор нь шинэчлэх шаардлага тулгарч байна.

Цаашид тэтгэврийн олон давхаргат тогтолцоонд үе шаттайгаар шилжих, хийсвэр нэрийн дансны тогтолцооны үр нөлөө, тэтгэврийн нөөц сангийн хэтийн төлөвт нарийвчилсан дүн шинжилгээ хийх, залуу үеийн оролцоог нэмэгдүүлэх, хамрагдалтыг өргөжүүлэх бодлогын цогц шийдлийг боловсруулах шаардлагатай байна.

Иймд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь тэтгэврийн тогтолцооны өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, олон улсын сайн туршлагад тулгуурлан Монгол Улсын онцлогт нийцсэн шинэчлэлийн стратеги, замын зураглал боловсруулах, холбогдох хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр мэргэжлийн дэмжлэг үзүүлэх ахлах зөвлөх ажиллуулахаар төлөвлөж байна. Энэхүү ажлын даалгавар нь тэтгэврийн шинэчлэлийн ахлах зөвлөхийн гүйцэтгэх ажлын цар хүрээ болон нийлүүлэх бүтээгдэхүүнийг тодорхойлно.

Зөвлөх нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ГБХНХЯ) болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын (НДЕГ) холбогдох албан тушаалтнуудтай нягт хамтран ажиллаж, энэхүү ажлын даалгаварт тусгагдсан бүх үр дүн, бүтээгдэхүүнийг хугацаанд нь, мэргэжлийн түвшинд гүйцэтгэн хүлээлгэн өгөх үүрэгтэй байна.

**Ажлын зорилго:**

Тэтгэврийн шинэчлэлийн бодлогын шийдлийг боловсруулахад шаардлагатай хууль эрх зүйн дэмжлэг болон оролцогч талуудын ойлголт, хандлагыг үнэлэхэд дэмжлэгийг үзүүлнэ.

**Ажлын хүрээ:**

Зөвлөх нь дараах үндсэн ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Одоогийн тэтгэврийн тогтолцоонд түргэвчилсэн нэмэлт дүн шинжилгээ хийх (олон улсын байгууллага, судлаачдын хийсэн тайлан, нийгмийн даатгалын сангийн мэдээлэлд тулгуурлан);
- Тэтгэврийн даатгалын хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл, холбогдох баримт бичгийн төсөл боловсруулахад ГБХНХЯ-тай хамтран ажиллах;
- Тэтгэврийн шинэчлэлтэй холбоотойгоор оролцогч талуудын хэрэгцээ, хандлага, ойлголт, мэдээллийн шаардлагын шинжилгээг хийх (олон нийт, шийдвэр гаргагчид/бодлого боловсруулагчид, ажил олгогчид, даатгуулагчид болон тэтгэвэр авагчид хамаарна);
- Оролцогч тал бүрт зориулан тэдний онцлог хэрэгцээ, ойлголт, хүлээлтэд нийцүүлэн гол мэдээлэл, харилцааны мессежүүдийг боловсруулахад ГБХНХЯ, НДЕГ-т дэмжлэг үзүүлэх.

**Гүйцэтгэх ажлууд:** Зөвлөх нь нь дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

**1. Тэтгэврийн даатгалын өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ хийх:**

- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль болон холбогдох баримт бичгийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх;
- Тэтгэврийн шинэчлэлийн хувилбаруудын давуу, сүл тал, эрсдэл, хэрэгжих боломж зэргийг харьцуулан боловсруулах (Олон улсын байгууллагуудын дүн шинжилгээ, судлаачдын тайлан, олон улсын түршлагыг харгалзан);
- Цалинд үндэслэн тэтгэвэр бодохдоо “хамгийн өндөр орлоготой дараалсан таван жилийн дундаж цалин”-г ашигладаг одоогийн зохицуулалт нь албан болон албан бус хөдөлмөр эрхлэлтийн хооронд шилжин ажиллагчид, түүнчлэн байнгын бус болон улирлын чанартай ажил эрхлэгчдийн тэтгэврийн эрх, тэтгэврийн хэмжээнд хэрхэн нөлөөлж буй байдал, нөлөөллийн цар хүрээг үнэлж, илэрсэн асуудлыг шийдвэрлэх бодлогын хувилбарын санал боловсруулах;
- Тэтгэврийн даатгалын хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл, холбогдох баримт бичгийн төсөл боловсруулахад ГБХНХЯ-тай хамтран ажиллах;

**2. Тэтгэврийн шинэчлэлийн талаар оролцогч талуудын ойлголтыг үнэлэх:**

- Оролцогч талуудын сегментчилэл болон хэрэгцээний шинжилгээний аргачлалыг боловсруулж, оролцогч талуудыг нийтлэг ашиг сонирхолтой болон/эсвэл өндөр анхаарал шаардлагатай бүлгүүдэд ангилах (оролцогч талуудад олон нийт, шийдвэр гаргагчид/бодлого боловсруулагчид, ажил олгогчид, даатгуулагчид болон тэтгэвэр авагчид хамаарна);
- Хэвлэл мэдээллийн агуулгад мониторинг хийсний үндсэн дээр оролцогч талуудын гол ашиг сонирхол, ойлголт, хандлагыг шинжилж, тэдгээрийг тодорхой, бүтэцтэй байдлаар нэгтгэн боловсруулах;
- Оролцогч тал тус бүрийн онцлог, ойлголт, мэдээллийн хэрэгцээ (буруу ойлголт, ташаа ойлголт зэрэг)-г тодорхойлсон танилцуулга бэлтгэх, танилцуулах;
- Оролцогч талуудын ойлголт, хэрэгцээнд нийцүүлэн боловсруулсан мессежүүдийг боловсруулах, сайжруулах чиглэлээр яаманд дэмжлэг үзүүлэх.

**Тайлбар:**

- Энэхүү зөвлөх үйлчилгээ нь зөвхөн ГБХНХЯ-ны бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд хэрэгжинэ. Зөвлөх нь энэхүү ажлын даалгаврын хүрээнд боловсруулсан аливаа мэдээлэл, дүн шинжилгээ, судалгааг гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүрэгтэй. Ажлын даалгаврын хүрээнд боловсруулсан бүх судалгаа, дүн шинжилгээ нь ГБХНХЯ-ны өмч байна.

## Нийлүүлэх бүтээгдэхүүн:

### Бүтээгдэхүүн 1.

1.1. Ажлын аргачлал, ажлын төлөвлөгөө

1.2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль болон холбогдох баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээний тайлан, тайлангийн слайд (PowerPoint) танилцуулгын хамт.

1.3. Цалинд үндэслэсэн аргаар тэтгэвэр бодохдоо “хамгийн өндөр орлоготой дараалсан таван жил”-ийн дундаж цалинг ашигладаг зохицуулалт нь албан болон албан бус салбар хооронд шилжин ажиллагчид, түүнчлэн байнгын бус болон улирлын чанартай ажил эрхлэгчдийн хуримтлагдсан тэтгэврийн эрх, тэтгэврийн хэмжээнд үзүүлж буй нөлөөлөл, нөлөөллийн цар хүрээний үнэлгээ, цаашид баримтлах бодлогын хувилбарын санал<sup>1</sup>.

1.4. Тэтгэврийн шинэчлэлийн хувилбаруудын давуу, сул тал, эрсдэл, хэрэгжих боломж зэргийг харьцуулалсан ажлын тайлан.

### Бүтээгдэхүүн 2.

2.1. Оролцогч талуудын хэрэгцээний үнэлгээний тайлан;

2.2. Бүх оролцогч талуудын шинж чанар, ойлголт, мэдээллийн хэрэгцээг эцэслэн тодорхойлсон тайлан;

2.3. Оролцогч тал бүрт зориулан тэдний онцлог хэрэгцээ, ойлголт, хүлээлтэд нийцүүлэн гол мэдээлэл, харилцааны мессежүүдийг боловсруулахад дэмжлэг үзүүлж ажилласан ажлын тайлан.

Гэрээний хугацаа: 2026.06.15. - 2026.11.16 (5 сар)

**Гэрээний үнэ: 54,000,000 төгрөг.**

#### **Мониторинг, явцын хяналт, тайлагналтад тавигдах шаардлагууд:**

Зөвлөх нь дээр дурдсан ажлыг ГБХНХЯ болон НТХН-ийн удирдамж, хяналтын дор гүйцэтгэнэ. Зөвлөхийн ажлын гүйцэтгэлийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

- 1) Ажлын даалгаварт тусгасан ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн байдал;
- 2) Төлөвлөсөн ажлуудаа хугацаанд нь хэрэгжүүлсэн байдал;
- 3) Гүйцэтгэсэн ажлын чанар.

#### **Тайлагналт:**

Зөвлөх нь ГБХНХЯ болон НТХН-д ажлаа тайлагнаж ажиллана. Зөвлөх нь гэрээний төлбөрийн хуваарьт заасан төлбөр авахын өмнө ГБХНХЯ болон НТХН-д Бүтээгдэхүүн хүлээж авах маягыг бөглөж ирүүлнэ.

#### **Төлбөрийн хуваарь:**

Гэрээний үнийн дүн нь энд заасан хугацааг сунгасан эсэхийг үл харгалзан үр дүнд суурилсан тогтсон дүн байна. Гэрээний төлбөрийг дараах хуваарийн дагуу төлнө:

Бүтээгдэхүүн	Төлбөр
Бүтээгдэхүүн 1.1 and 1.2	Зөвлөх үйлчилгээний ажлын хөлсний 30%
Бүтээгдэхүүн 1.3 and 1.4	Зөвлөх үйлчилгээний ажлын хөлсний 40%
Бүтээгдэхүүн 2.1, 2.2 and 2.3	Зөвлөх үйлчилгээний ажлын хөлсний 30%

Зөвлөхийн нийлүүлсэн бүтээгдэхүүнийг ГБХНХЯ/НТХН хүлээн авсны дараа төлбөрийг олгоно.

## ШААРДАГАТАЙ УР ЧАДВАР, АЖЛЫН ТУРШЛАГА

Зөвлөх нь дараах шаардлагыг хангасан байна:

**Боловсрол:**

<sup>1</sup> Дээрх ажлыг дата аналит зөвлөхтэй хамтран гүйцэтгэнэ.

- Эдийн засаг, санхүү, нийтийн удирдлага, даатгал эсвэл холбогдох чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх;

**Туршлага:**

- Бодлогын шинжилгээ, стратеги боловсруулах ажилд ажилласан туршлагатай;
- Нийгмийн даатгал, тэтгэврийн даатгалтай холбоотой ажлын туршлагатай;Хууль эрх зүйн орчны шинжилгээ хийж байсан туршлагатай байх;
- Олон улсын байгууллага (Дэлхийн банк, АХБ, ОУХБ, НҮБ)-тай хамтран ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.

**Ур чадвар:**

- Бодлогын дүн шинжилгээ хийх, стратеги төлөвлөх өндөр чадвартай;
- Тайлан, бодлогын баримт бичгийг мэргэжлийн түвшинд бичих чадвартай;
- Багаар ажиллах, асуудлыг цогцоор зохицуулах ур чадвартай;
- Монгол, Англи хэлний өндөр түвшний мэдлэгтэй.